

**“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ  
(шинэчилсэн найруулга)**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү дүрэм нь “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үндсэн баримт бичиг мөн./ЗГ-ын 2014-1-11-ний 9-р тогтоолоор дүрмийн нэр, 1.1, 1.2-т өөрчлөлт орсон/

1.2. Компанийн оноосон нэр нь “Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “Эрдэнэс Монгол” ХХК буюу “ЭМГЛ” ХХК (англиар “Erdenes MGL” limited liability company, товчилсон нэр нь “Erdenes MGL” LLC буюу “EMGL” LLC) болно.

1.3. Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа буюу гүйцэтгэх удирдлага байршиж байгаа газрын хаягаар тодорхойлно.

1.4. Компани нь өөрийн бэлгэдэл (лого, туг)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

**Хоёр. Компанийн эрх зүйн байдал**

2.1. Компани нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль, хууль тогтоомжийн бусад акт, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

2.2. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд байна.

2.3. Хувьцаа эзэмшигч компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчийн хариуцлагыг хүлээхгүй.

**Гурав. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зарчим**

3.1. Компани нь дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна:

3.1.1. стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялаг (цаашид хамтад нь “орд” гэх)-ийг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх чиглэлээр:

3.1.1.1. ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших;

3.1.1.2. ордыг ашиглах үеийн төрд ногдох дараах ашгийг төвлөрүүлэх:

3.1.1.2.1. ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого;

3.1.1.2.2. орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээлийн тодорхой хэсэг.

3.1.2. орд ашиглалтын чиглэлээр:

3.1.2.1. ордын геологийн судалгаа, эрдэм шинжилгээ, эрэл, хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээр гүйцэтгэх;

3.1.2.2. ордыг дангаараа болон бусад этгээдтэй хамтран ашиглах;

3.1.2.3. орд ашиглах гэрээ байгуулах ажлын бэлтгэлийг хангах, Засгийн газраас эрх олгосноор орд ашиглах гэрээ байгуулах;

3.1.2.4. ордыг түшиглүүлэн ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах, хувьцааг нь эзэмших;

3.1.2.5. ордын дэд бүтцийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах, дэд бүтцийн төсөл хөтөлбөрийг бие даан болон бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдах;

3.1.2.6. ордын ложистикийн үйлчилгээ, бүтээгдэхүүн тээвэрлэх, дамжуулан тээвэрлэх, агуулахын болон гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ эрхлэх;

3.1.2.7. ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх.

3.1.3. тусгай зөвшөөрөл, эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах чиглэлээр:

3.1.3.1. ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших, бүхлээр нь эсвэл тодорхой хэсгийг буцаан өгөх, бусдад шилжүүлэх, шилжүүлэн авах, барьцаалах;

3.1.3.2. ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн шилжилт, хөдөлгөөнд хяналт тавих, тооллогыг зохион байгуулахад оролцох;

3.1.3.3. орд ашиглалттай холбоотой аливаа эд хөрөнгө, тоног төхөөрөмж болон оюуны өмчийн эрхийг эзэмших, ашиглах, түрээслэх, түрээслүүлэх, худалдаж авах, худалдах;

3.1.3.4. барилга байгууламж, бусад үл хөдлөх хөрөнгө худалдаж авах, барих, өмчлөх, эзэмших, ашиглах, түрээслэх, барьцаалах.

3.1.4. санхүүжилт татах, олгох чиглэлээр:

3.1.4.1. ордын ашиглалт болон энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор зээл авах, бусад хэлбэрээр хөрөнгө оруулалтыг татах;

3.1.4.2. хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох, бусад хэлбэрээр хөрөнгө оруулах;

3.1.4.3. эрх бүхий байгууллагын шийдвэрээр өрийн бичиг (бонд) гаргах.

3.1.5. борлуулалт, худалдааны чиглэлээр:

3.1.5.1. уул уурхайн бүтээгдэхүүнийг (олборлосон, баяжуулсан, боловсруулсан бүтээгдэхүүн) гадаад, дотоод зах зээл дээр борлуулах, холбогдох гэрээ хэлцлийг байгуулах;

3.1.5.2. уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа явуулах;

3.1.5.3. бүтээгдэхүүний экспорт, импорттой холбогдуулан хилийн боомт, нэвтрэх гарцын барилга байгууламж барих, эзэмших, ашиглах.

3.1.6. зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:

3.1.6.1. орд ашиглалтын техник-эдийн засгийн үндэслэл, нөөцийн үнэлгээ, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлт хийх;

3.1.6.2. ордын ашиглалтын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, нөхөн сэргээлт хийх;

3.1.6.3. ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, стратегийн хөрөнгө оруулагчийг татан оролцуулах;

3.1.6.4. ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотойгоор ордын тухай мэдээллийг дотоод, гадаадад сурталчлан таниулах, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

3.1.6.5. ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааг дотоод, гадаадын хөрөнгийн биржид бүртгүүлэн, арилжаалахад оролцох.

3.1.7. энэхүү дүрмийн 3.1.1.1-д зааснаас бусад улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордыг ашиглахтай холбоотой харилцаанд эрх бүхий байгууллагын шийдвэрээр төрийн төлөөллийг хэрэгжүүлэх;

3.1.8. энэхүү дүрмийн 3.1.7-д зааснаас бусад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аливаа хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлэн авах, эзэмших, худалдах.

3.2. Компани нь хуулиар хориглоогүй аливаа үйл ажиллагааг эрхлэн явуулж болох бөгөөд тэдгээр үйл ажиллагааг өөрийн салбар, охин компаниудаараа дамжуулан гүйцэтгэж болно.

3.3. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулна.

3.4. Компани нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

3.4.1. бие даасан байх;

3.4.2. олон нийтэд ил тод байх;

3.4.3. байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашигт автагдахгүй байх.

### **Дөрөв. Компанийн хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгө**

4.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 1 (нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100.000.000 (нэг зуун сая) ширхэг энгийн, нэг бүр нь 1 (нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3.000.000 (гурван сая) ширхэг давуу эрхийн хувьцаа байна.

4.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцааны үнийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

4.3. Компани нь Монгол Улсын иргэн бүрт олгох давуу эрхийн хувьцааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн сангийн албан ёсны тоон мэдээлэлд үндэслэн гаргах бөгөөд тухайн төрлийн давуу эрхийн хувьцааны үнэ, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон нөхцөл эсхүл энэхүү дүрэмд зааснаар гаргана.

4.4. Компанийн давуу эрхийн хувьцааг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.1-д заасан хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх бөгөөд давуу эрхийн хувьцааг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах, өв залгамжлахыг хориглоно.

4.5. Компанийн хувьцаа нь биет бус хэлбэртэй байх бөгөөд компани нь энгийн хувьцааны бүртгэлийг хөтөлж, түүнийг хадгалах ажлыг зохион байгуулна. Давуу эрхийн хувьцааг эзэмших, эзэмших эрх дуусгавар болсон тухай бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

4.6. Хүний хөгжил сангийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь зөвхөн Хүний хөгжил сангаар дамжуулан ногдол ашиг хүртэх эрхтэй.

4.7. Компанийн энгийн хувьцаа нь Засгийн газраас холбогдох шийдвэр гарах хүртэл гагцхүү төрийн мэдэлд байх бөгөөд аливаа хэлбэрээр бусдад арилжаалагдахгүй.

4.8. Компани нь цаашид нэмж хувьцаа болон бусад үнэт цаас зарлах бол тэдгээрийн тоо, гаргах хугацаа, нөхцөлийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.9. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

4.10. Компанийг үүсгэн байгуулах үе болон нэмэлт хувьцаа гаргах үед гаргасан хувьцааны төлбөрийг мөнгө, үнэт цаас, бусад хөрөнгө болон хөрөнгийн эрхээр хийж болно.

### **Тав. Хувьцаа эзэмшигчдийн хурал**

5.1. Компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг Засгийн газар хэрэгжүүлнэ.

5.2. Улсын Их Хурал нь бүрэн эрхийнхээ хүрээнд хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.3. Засгийн газар нь бүрэн эрхийнхээ хүрээнд энэхүү дүрэм болон хууль, тогтоомжоор Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарахаас бусад компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг өөрийн үйл ажиллагаа явуулах журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3.1. компани нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

5.3.2. компанийн хэлбэрийг өөрчлөх;

5.3.3. охин болон хараат компани байгуулах, татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

5.3.4. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

5.3.5. компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэх;

5.3.6. компанийн гаргасан давуу эрхийн хувьцаанаас бусад үнэт цаасыг худалдах, худалдан авах, эргүүлэн авах шийдвэр гаргах;

5.3.7. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх;

5.3.8. компани нь улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийж нөөцийг нь тогтоосон ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших шийдвэр гаргах;

5.3.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

5.3.10. хэрэв Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх асуудлыг шийдвэрлэж чадаагүй бол тэдгээрийн талаар шийдвэр гаргах;

5.3.11. компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

5.4. Шаардлагатай гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээний асуудлыг Засгийн газарт хэдийд ч тавьж шийдвэрлүүлж болно.

5.5. Засгийн газар нь хувьцаа эзэмшигчийн хувьд компанийн хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэн, бие даасан, үр ашигтай үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, компанийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аливаа бодлого, шийдвэрээр тогтвортой дэмжиж ажиллана.

5.6. Улсын Их Хурал, Засгийн газар нь хууль тогтоомж болон энэхүү дүрмээр бүрэн эрхэд нь хамааруулснаас бусад асуудлаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шууд оролцохгүй.

5.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн бүрэлдэхүүнд багтдаг аж ахуйн үйл ажиллагаа явуулж ашиг олдоггүй менежмент, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхэлдэг охин болон хараат компанийн санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

### **Зургаа. Төлөөлөн удирдах зөвлөл**

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

6.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 (есөн) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийг Хүний хөгжил сангийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшүүлж, томилж, чөлөөлнө.

6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь түүний хурал байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлага гэж үзвэл нэмэлт хурлыг хэдийд ч хийж болно.

6.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг байнгын, тогтмол, мэргэшсэн явуулах зорилгоор дараах хороодыг байгуулж ажиллуулах бөгөөд бусад тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

6.4.1. нэр дэвшүүлэх;

6.4.2. аудитын;

6.4.3. цалин, урамшууллын.

6.5. Хороод нь тус бүр 3 (гурван) гишүүнтэй байх бөгөөд гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс Төлөөлөн удирдах зөвлөл томилно.

6.6. Хороо нь өөрийн хариуцсан асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлд санал, дүгнэлт оруулж, хэлэлцүүлэх бөгөөд шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

6.7. Хороо нь өөрийн эрх, үүргийг тусгасан үйл ажиллагааны журмын төслийг компанийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

6.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

6.8.1. компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах;

6.8.2. компанийн төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

6.8.3. бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн төлөвлөгөөг батлах;

6.8.4. компанийн хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох;

6.8.5. компанийн стратегийн зорилтуудыг тодорхойлж, урт хугацааны болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг батлах;

6.8.6. толгой болон охин, хараат компани хоорондын харилцааг зохицуулсан аливаа дүрэм журам, гэрээг батлах;

6.8.7. компанийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын дээд хязгаарыг тогтоох;

6.8.8. компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлыг томилуулах, чөлөөлүүлэх саналыг Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх;

6.8.9. компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх,

хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;/ЗГ-ын 2014-1-11-ний 9-р тогтоолоор өөрчлөлт орсон/

6.8.10. компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, нээж ажиллуулах, татан буулгах, удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

6.8.11. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

6.8.12. эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

6.8.13. компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

6.8.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг болон төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын дүрэм, журмыг батлах;

6.8.15. компанийн шинээр худалдаж авах болон акталж, данснаас хасах эд хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэх;

6.8.16. худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

6.8.17. компанид орсон орлогыг хуваарилах, хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээг тогтоох, батлах;

6.8.18. охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх компанийн эрх бүхий албан тушаалтныг томилох, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт компанийг буюу хувьцаа эзэмшигчийг төлөөлж оролцох этгээдийн өгөх саналын удирдамжийг батлах;

6.8.19. компанийн мэдэлд үлдээсэн эрсдэлийн хуримтлалын хэмжээг тодорхойлох, зарцуулах журмыг батлах;

6.8.20. хуульд өөрөөр заагаагүй бол компанийн зүгээс улсын төсөв болон хүний хөгжил сангийн төсөвт төвлөрүүлэх орлого буюу ногдол ашгийн хэмжээг тодорхойлох;

6.8.21. их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийн үнэ болон хийх эсэх талаар шийдвэр гаргах;

6.8.22. хуулийн этгээд байгуулах, татан буулгах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө худалдах талаар Засгийн газарт санал оруулах;

6.8.23. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор компанийн тэргүүн дэд захирал, дэд захирлыг томилж, чөлөөлөх;

6.8.24. тухайн компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол гаргасан хувьцааг нь 100 (зуун) хувь эзэмшдэг охин компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг өөрөө эсхүл энэхүү дүрмийн 6.8.18-д заасны дагуу хэрэгжүүлэх, охин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, охин компанийн гүйцэтгэх захирлыг томилж, чөлөөлөх;

6.8.25. энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээс бусад бүх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

6.8.26. хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасан бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

6.8.27. компанийн үйл ажиллагаатай уялдуулан хөрөнгө оруулалтын, үйлдвэрлэл технологийн, ордын нөөцийн хяналтын, шинжлэх ухаан, техник технологийн, эрсдэлийн удирдлагын болон шаардлагатай бусад чиглэлээр орон тооны болон орон тооны бус зөвлөл, бусад нэгжийг байгуулах асуудлыг Засгийн газарт оруулж, шийдвэрлүүлэх.

6.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос Төлөөлөн удирдах зөвлөлийн санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

6.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, түүнд хяналт тавих үүргийг хүлээнэ.

6.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаас үүрэг болгосны дагуу аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

6.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аль нэг хорооны даргын ажлыг хавсран гүйцэтгэхгүй.

6.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдуулна.

6.14. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонхи гуравны хоёр (2/3) оролцсоноор хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхи гуравны хоёр (2/3)-ын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

6.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн зөвхөн өөрийн биеэр хуралд оролцож эрх хэмжээгээ хэрэгжүүлэх бөгөөд өөр этгээдээр төлөөлүүлж хуралд оролцохыг хориглоно. Хэрэв Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн хуралд биеэр оролцоогүй ч тухайн хэлэлцэж буй асуудлын талаар бичгээр санал гаргасан бол түүнийг хуралд оролцсонд тооцно.

6.16. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудал хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

6.17. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

6.18. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь цалин, урамшуулалтай байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ нь Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагаас тусгайлан тогтоосон жишиг хэмжээтэй нийцэхүйц байна.

6.19. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд 1 (нэг)-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

### **Долоо. Компанийн гүйцэтгэх удирдлага**

7.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирлаар удирдуулсан тэргүүн дэд, дэд захирал, санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга бүхий баг хэрэгжүүлнэ./ЗГ-ын 2014-1-11-ний 9-р тогтоолоор өөрчлөлт орсон/

7.2. Гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөлийн санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

7.3. Гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийн эрх ашгийн төлөө түүнийг Монгол Улс болон хилийн чанадад төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

7.4. Гүйцэтгэх захирал нь гүйцэтгэх удирдлагын гишүүн тус бүртэй гэрээ байгуулах бөгөөд гэрээнд тэдний эрх, үүрэг, цалин, шагнал урамшуулал, хангамж, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээ болон бусад асуудлыг тусгана./ЗГ-ын 2014-1-11-ний 9-р тогтоолоор өөрчилсөн/

7.5. Гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулал олгох журмыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батална.

7.6. Гүйцэтгэх захирал нь албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, компанийн нэр хүнд, эдийн засгийн байдалд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогдвол Төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхийг зогсоох тухай саналаа Засгийн газарт гаргаж, шийдвэрлүүлнэ.

7.7. Гүйцэтгэх удирдлагын гишүүдийн албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, компанийн нэр хүнд, эдийн засгийн байдалд ноцтой хохирол учруулсан болох нь тогтоогдвол Төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг хэлэлцэж, шийдвэрлэнэ.

7.8. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

7.8.1. менежментийн өндөр ур чадвартай, 10 (арав)-аас доошгүй жил удирдах ажил гүйцэтгэж байсан дадлага туршлагатай, дээд боловсролтой байх;

7.8.2. зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

7.8.3. ял шийтгэлгүй байх;

7.8.4. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

7.9. Гүйцэтгэх захирал нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

7.9.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд 2 (хоёр)-оос доошгүй удаа ажлын үр дүнгээ тайлагнан дүгнүүлэх;

7.9.2. компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх үүрэгтэй бөгөөд түүний үнэн зөвийг хариуцах;

7.9.3. компанийн дотоод журам, заавар, аргачлал, ажил үүргийн хуваарь баталж мөрдүүлэх, компанийн ажиллагсдад сахилгын шийтгэл ногдуулах;

7.9.4. хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалт, компанийн хөдөлмөрийн дотоод журамд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

7.9.5. компанийн дотоод хянан шалгагчийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний дагуу томилох;

7.9.6. компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, жилийн төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

7.9.7. компанийн бодлого, түүний хэрэгжилттэй холбогдсон асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагатай шууд харилцаж, байр сууриа илэрхийлэх;

7.9.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээний хүрээнд хамаарах асуудлаар компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;

7.9.9. компанийн нууцад хамаарах мэдээлэл, материалын жагсаалт болон нууц хамгаалах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан мөрдүүлэх;

7.9.10. энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

7.9.11. гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

7.9.12. үүрэг гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

7.9.13. компанийн бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;

7.9.14. компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулах;

7.9.15. компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

7.9.16. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ажлыг хариуцан зохион байгуулах;

7.9.17. компанийн бэлгэдэл, тэмдгийн загварыг батлах;

7.9.18. эрх бүхий байгууллагаас гаргасан бодлого чиглэлтэй уялдуулан толгой болон охин компанийн үйл ажиллагааны уялдааг хангах үүднээс холбогдох дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөл, охин компаниудын эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

7.9.19. охин болон хараат компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол толгой компанийн нэрийн өмнөөс охин болон хараат компаниудаас холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг гаргуулан авах, тайлан тэнцэлтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаар шалгуулах;

7.9.20. хууль болон энэхүү дүрэм, гэрээнд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

7.10. Гүйцэтгэх захирал нь эрх, үүргээ түр хугацаанд компанийн бусад эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.11. Компанийн гүйцэтгэх удирдлага нь энэхүү дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон тооны болон орон тооны бус мэргэжлийн зөвлөх буюу зөвлөх багийг авч ажиллуулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлж болно.

### **Найм. Охин болон хараат компани, салбар, төлөөлөгчийн газар**

8.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн дангаараа болон бусад хуулийн этгээдтэй хамтран хараат болон охин компанийг үүсгэн байгуулах, тухайн хуулийн этгээдийн хувьцааг нь шилжүүлж болон худалдан авах замаар охин болон хараат компани байгуулах тухай асуудлыг Засгийн газарт оруулж, шийдвэрлүүлнэ. Хараат болон охин компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна.

8.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай тохиолдолд салбар, төлөөлөгчийн газрыг дотоодод болон гадаад оронд нээн ажиллуулж болно.

8.3. Төлөөлөгчийн газар нь компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлсөн үйл ажиллагааг явуулна. Салбар нь компанийн үндсэн үйл ажиллагааг түүний нэрийн өмнөөс өөр газар нутагт явуулдаг этгээд байна.

8.4. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна. Тэдгээр нь компанийн албан ёсны хэвлэмэл хуудас, салбар төлөөлөгчийн газрын тэмдэг хэрэглэнэ.

8.5. Салбар, төлөөлөгчийн газрын захирлыг гүйцэтгэх удирдлагын санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

#### **Ес. Охин болон хараат компанитай харилцах харилцаа, компанийн нэгдэл**

9.1. Компани нь охин болон хараат компанитай Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу өөрийн төлөөллөөр дамжуулан харилцахаас гадна өөрийн охин болон хараат компани, орд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч бусад хуулийн этгээдтэй Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газар, төрийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн гэрээ байгуулж хамтран ажиллаж болно.

9.2. Энэхүү дүрмийн 9.1-д заасан гэрээнд толгой компанийн зүгээс хэрэгжүүлэх удирдлагын, санхүүгийн, техникийн хяналтын тогтолцоо, харилцан хүлээх эрх, үүрэг зэргийг тодорхойлно.

9.3. Компани нь өөрийн охин болон хараат компани дахь төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээтэй уялдуулан тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын тодорхой албан тушаалд өөрийн төлөөллийг ажиллуулах асуудлыг тухайн хамтрагч талтай тохиролцож шийдвэрлэнэ.

9.4. Компани, түүний охин болон хараат компаниудыг хамтад нь компанийн нэгдэл гэх бөгөөд нэгдлийн хамаарал бүхий компаниудын нийтлэг эрх ашиг, үйл ажиллагаанд хамаарах асуудлыг зохицуулах үүднээс тэдгээрийн гүйцэтгэх удирдлагуудын хүрээнд тодорхой бүтцийг байгуулан ажиллуулж болно.

9.5. Компани нь аливаа хуулийн этгээдийн төрийн мэдэл (эзэмшил)-ийн хувьцааг эзэмших эрхийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу өөрөө болон охин компаниараа дамжуулан хэрэгжүүлж болно.

9.6. Компани нь охин болон хараат компани дахь төрийн эзэмшлийн хувьцааны эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс эрх олгосон этгээд болон гүйцэтгэх удирдлага хамтран хэрэгжүүлнэ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс эрх олгосон этгээд болон гүйцэтгэх удирдлага нь компанийн буюу хувьцаа эзэмшигчийг төлөөлөх эрхээ хэрэгжүүлэхдээ энэхүү дүрэмд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан саналын удирдамжийг үндэслэх бөгөөд энэхүү удирдамжаас өөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно.

9.7. Төлөөлөн удирдах зөвлөл нь компани болон түүний охин болон хараат компанийн хэвийн үйл ажиллагаа доголдож, санхүүгийн зохистой харьцаа, үзүүлэлт алдагдсан тохиолдолд аудитын дүгнэлтийг үндэслэн үйл ажиллагааг нь тогтворжуулж, хүндрэлийг даван туулахад чиглэсэн тодорхой төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр эсхүл өөрөө бие даан хэрэгжүүлж болно.

9.8. Охин болон хараат компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх журмыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү дүрэмд нийцүүлэн батална.

### **Арав. Хэлцэл хийх ерөнхий журам**

10.1. Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуульд зааснаар тодорхойлж, хэрэгжүүлэх бөгөөд энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол их хэмжээний хэлцэлд компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон байнга хийдэг болон түүхий эд, материал авах, бэлэн бүтээгдэхүүнийг борлуулах хэлцэл хамаарахгүй.

10.2. Энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол 50.000.000 (тавин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хэлцэл хийх зөвшөөрлийг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

10.3. Хэлцлийн дүн нь энэхүү дүрмийн 10.1, 10.2-т заасан хэмжээнээс бага боловч тухайн хэлцэл болон түүнтэй холбоотой бусад хэлцлүүдийн нийт үнийн дүнгийн нийлбэр нь 10.1, 10.2-т заасан хэмжээнээс илүү гарсан бол энэхүү дүрмийн 10.1, 10.2-т заасныг баримтална.

10.4. Тухайн хэлцлийг их хэмжээний хэлцэл мөн эсэхийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл тогтоох бөгөөд ингэхдээ аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшны уналтын төвшинтэй уялдуулан шинэчилж дахин тогтоож болно.

10.5. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

10.6. Компанийн тухай хуулийн 89.4-т заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлтэй холбоотой заалтууд (нэг талаас) компани, (нөгөө талаас) хувьцаа эзэмшигч, мөн (нэг талаас) компани, (нөгөө талаас) охин болон хараат компани эсхүл хувьцаа эзэмшигчийн харилцан холбоотой бусад компанитай хийсэн аливаа хэлцлийн хувьд хамаарахгүй. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн тус бүр нь тийм хэлцэлд санал өгч болно.

10.7. Компани нь санхүүгийн жилийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл, тэдгээрийн үнийн талаархи мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

### **Арван нэг. Компанийн эрх бүхий албан тушаалтан**

11.1. Компанийн тухай хуулийн 84.1-д заасны дагуу дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно:

11.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн;

11.1.2. гүйцэтгэх захирал;

11.1.3. тэргүүн дэд захирал, дэд захирал;

11.1.4. санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга;

11.1.5. ерөнхий нягтлан бодогч;

11.1.6. ерөнхий мэргэжилтэн;

11.1.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга;

11.1.8. газрын захирал, хэлтсийн дарга;

11.1.9. шийдвэр гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцож буй бусад этгээд.

11.2. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуульд заасны дагуу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаархи болон бусад мэдээллийг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд өгч энэхүү дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

11.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй байна:

11.3.1. хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх;

11.3.2. үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх;

11.3.3. үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар явуулж, хувьцаа эзэмшигч, харилцагч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх;

11.3.4. шууд болон шууд бус байдлаар эсхүл гуравдагч талын нэрийн өмнөөс компанид нөлөөлж болох аливаа хэлцэл, материаллаг сонирхолтой асуудлын талаар төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх;

11.3.5. компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах;

11.3.6. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөл, аудитор мэдэгдэх;

11.3.7. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн этгээдээс бэлэг, урамшуулал авахгүй байх;

11.3.8. компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 (арав) хоногийн дотор Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлд заасан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орох бүрт 10 (арав) хоногийн дотор компанид мэдэгдэнэ;

11.3.9. компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахгүй байх.

11.4. Компанитай байгуулсан гэрээгээр илүү урт хугацаа тогтоогоогүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 (гурав) жилийн туршид энэ дүрмийн 11.3.9-д заасан үүргийг хүлээнэ.

### **Арван хоёр. Компанийн хяналтын тогтолцоо**

12.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

12.1.1. хяналтын зөвлөл;

12.1.2. дотоодын хяналт;

12.1.3. хөндлөнгийн хяналт.

12.2. Компанийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих чиг үүргийг хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

12.3. Хяналтын зөвлөл 5 (таван) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийг Хүний хөгжил сангийн тухай хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.

12.4. Хяналтын зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах эрх эдэлнэ:

12.4.1. хяналтын зөвлөлийн шийдвэр, хөндлөнгийн аудиторын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар компанийн мэдээллийг хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх;

12.4.2. компаниас эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцах;

12.4.3. компанийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

12.4.4. компанийн гаргасан шийдвэр, үйл ажиллагааны талаар гаргасан гомдолтой холбоотой тайлан, мэдээлэл, шаардлагатай бусад бичиг баримтыг компаниас гаргуулан авах, гомдлыг хянах;

12.4.5. компанийн эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан шийдвэртэй холбогдуулан гаргасан гомдлыг хянах;

12.4.6. компанийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулах шаардлагыг компанийн удирдлагад хүргүүлэх.

12.5. Хяналтын зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах үүрэг хүлээнэ:

12.5.1. компанийн жилийн санхүүгийн тайланд аудит хийх аудитын байгууллагыг сонгоход хяналт тавих;

12.5.2. аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар компаниас хийж байгаа ажилтай танилцаж, биелэлтийг нь хянах;

12.5.3. хяналтын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.

12.6. Хяналтын зөвлөлийн дарга нь тус зөвлөлийн гишүүний эрхээс гадна дараах эрхтэй байна:

12.6.1. хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хуралдааныг товлох, даргалах;

12.6.2. хяналтын зөвлөлийн даргын түр эзгүйд, түүний үүргийг орлон гүйцэтгэх гишүүнийг томилох;

12.6.3. хяналтын зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих.

12.7. Хяналтын зөвлөлийн гишүүн дараах эрх эдэлнэ:

12.7.1. хяналтын зөвлөлийн хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санал оруулах;

12.7.2. хяналтын зөвлөлийн шийдвэрийн дагуу компанийн үйл ажиллагаатай танилцах;

12.7.3. ажил үүргийн хуваарийн дагуу шаардлагатай бичиг баримтыг компаниас гаргуулан авах.

12.8. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн дараах үүрэгтэй:

12.8.1. хяналтын зөвлөлийн даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу тодорхой ажил хариуцан ажиллаж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар хяналтын зөвлөлийн хуралдаанд танилцуулах;

12.8.2. компанийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах;

12.8.3. хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хуралдаан товлон зарласан цагт хүрэлцэн ирэх;

12.8.4. хяналтын зөвлөлийн хуралдааны дэгийг сахих.

12.9. Хяналтын зөвлөлийн гишүүд компанийн эрх бүхий албан тушаалтан байхыг хориглоно.

12.10. Хяналтын зөвлөл нь компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон компанийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын Их Хурал, Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

12.11. Хяналтын зөвлөл нь компанийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэхдээ энэхүү дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

12.12. Хяналтын зөвлөлийн даргыг хяналтын зөвлөлийн гишүүдээс нэр дэвшүүлэн хяналтын зөвлөлөөс олонхийн санал авсан хүнийг сонгоно.

12.13. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа хуралдана.

12.14. Хяналтын зөвлөлийн гишүүдийн 3 (гурав) болон түүнээс дээш гишүүн хуралд оролцоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхи гуравны хоёр (2/3)-ын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

12.15. Хяналтын зөвлөлийн хурлыг хуралдуулах, гомдлыг хянах болон бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлыг энэхүү дүрэмд нийцүүлэн Засгийн газраас баталсан хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

12.16. Компанийн гүйцэтгэх захирал, тэргүүн дэд захирал, дэд захирал болон бусад эрх бүхий албан тушаалтан нь хяналтын зөвлөлийн шаардлагаар компанийн аж ахуйн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л баримт, материалыг саадгүй танилцуулж, шалгуулах, шалгалт явуулах нөхцөлөөр хангах үүрэгтэй.

12.17. Дотоодын хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хянан шалгагч хэрэгжүүлнэ. Дотоод хянан шалгагчийн ажиллах журмыг Төлөөлөн удирдах зөвлөл батална. Дотоодын хяналт нь байнгын ажиллагаатай байна.

12.18. Компани нь хөндлөнгийн хяналтын зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах бөгөөд санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хөндлөнгийн аудитын компаниар гүйцэтгүүлнэ.

12.19. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооноос гаргасан саналыг үндэслэн компанийн аудиторыг сонгож, түүнтэй гэрээ байгуулна.

12.20. Дараах этгээдийг компанийн аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно:

12.20.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн гэрээний үндсэн дээр хөлсөөр ажиллаж буй ажилтан, эрх бүхий албан тушаалтан;

12.20.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан давуу эрхийн хувьцаанаас бусад үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг;

12.20.3. Аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар компанитай хэлцэл хийсэн, бизнесийн харилцаатай этгээд.

12.21. Хөндлөнгийн аудиторын тайланг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргана.

### **Арван гурав. Компанийн санхүүжилт болон ногдол ашиг**

13.1. Компани нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ:

13.1.1. төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсан орлогын тодорхой хэсэг;

13.1.2. орд ашиглахтай холбоотой авсан урьдчилгаа мөнгө, зээлийн тодорхой хэсэг;

13.1.3. бусад.

13.2. Тухайн санхүүгийн жилийн Хүний хөгжил сангийн төсвийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 30 (гуч)-иас доошгүй хоногийн өмнө улсын төсөв болон хүний хөгжил санд компанийн зүгээс төвлөрүүлэх орлогын хэмжээг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тодорхойлж шийдвэрийг Засгийн газар, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

13.3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс энэхүү дүрмийн 13.2-т заасан орлогын хэмжээг тодорхойлохдоо тухайн санхүүгийн жилийн компанийн төсөв, шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал, эрсдэлийн хуримтлалд үлдээх хөрөнгө (болзошгүй, өргөтгөлийн зардал, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн зардал, бусад бодит болон нөхцөлт өр төлбөрт шаардагдах хөрөнгө г.м) зэргийг нийт төвлөрүүлсэн хөрөнгөөс хасаж тооцно.

13.4. Улсын төсөв болон хүний хөгжил сангийн төсөвт компанийн зүгээс төвлөрүүлэх орлого нь энэхүү дүрмийн 3.1.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдэх бөгөөд энэ нь гагцхүү компанийн банкин дахь дансанд төвлөрнө.

13.5. Компани нь тухайн жилийн Төсвийн тухай хууль болон Хүний хөгжил сангийн төсвийн тухай хуулийн дагуу төвлөрүүлсэн орлого буюу ногдол ашгийг улсын төсөв болон хүний хөгжил санд шилжүүлнэ.

13.6. Компани нь давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашиг буюу хишиг хувийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу олгох бөгөөд давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнэ нь ногдол ашиг буюу хишиг хувь хүртэхэд нөлөөлөхгүй.

13.7. Компанийн тухайн жилийн эрсдэлийн хуримтлалд үлдээх хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрмийн 13.1-д заасан нийт орлогын 5 (таван) хувиас хэтрэхгүй байна.

### **Арван дөрөв. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа**

14.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

14.2. Компани нь охин компанитайгаа нэгдсэн санхүүгийн тайлан гаргана.

14.3. Компанийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх бөгөөд түүнийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн гүйцэтгэх захирал томилж, чөлөөлнө.

14.4. Компанийн санхүүгийн жил нь тухайн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

#### **Арван тав. Мэдээллийн нээлттэй байдал**

15.1. Компани өөрийн үйл ажиллагааны талаархи мэдээ, мэдээллийг тухай бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

15.2. Компани дараах мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр жил, хагас жил тутам нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлнэ:

15.2.1. компанийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, гарсан өөрчлөлт;

15.2.2. хагас жилийн болон жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

15.2.3. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

15.2.4. компанийн бусадтай байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаархи мэдээлэл;

15.2.5. төрөөс олгосон баталгаа болон аливаа бусад санхүүгийн туслалцаа, түүнчлэн компаниас бусдад гаргасан баталгаа, батлан даалтын талаархи мэдээлэл;

15.2.6. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нийтэд мэдээлэх шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

#### **Арван зургаа. Бусад зүйл**

16.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй аливаа асуудал нь Хүний хөгжил сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдаж, тайлбарлагдана.

16.2. Компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, компанитай гэрээгээр ажиллаж байгаа этгээд компанийн нууцад хамаарах мэдээллийг хууль тогтоомжид тусгайлан заасан буюу төрийн эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд компаниас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ашиглаж эсхүл задруулж болохгүй.

16.3. Компани нь албан хэргийн хөтлөлт болон бичиг баримтыг хадгалах, холбогдох байгууллагад шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулна.

16.4. Энэхүү дүрмийг зөрчиж гаргасан аливаа шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

---oOo---